

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
(2016 оны 3 дугаар улирлын байдлаар)**

Хяналт шалгалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх ерөнхий мэдээлэл:

- Зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А-58 дугаар тушаал, Банкны санхүүгийн тайлан, бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх загвар маягтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-200 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудад өгсөн үүрэг даалгавар болон холбогдох бусад хууль, тогтоомжуудын хүрээнд банкуудад зайнаас хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, банкуудаас сар бүр ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээг хянан шалгаж, тохируулгын гүйлгээ хийх шаардлагатай банкны тэнцэлд гүйлгээг хийж, тайлангийн хариуг сар бүр хүргүүлж байна.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А-151 дүгээр тушаалаар батлагдсан "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу банкуудаас 2016 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ирүүлсэн зохистой засаглалын хэрэгжилтийн тайланг хянаж үнэлгээ дүгнэлт өгөн, холбогдох хариуг 2016 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор банкуудад хүргүүлсэн.
- Банкуудын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын хүрээнд банкуудын санхүү, төлбөрийн чадварын талаарх ерөнхий дүгнэлт, мэдээллийг боловсруулж, банкуудаас ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг, материалыг хууль, журам, зааврын дагуу шалгаж удирдлагад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулах, банкинд хийх хяналт

шалгалтыг хугацаанд нь чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч байна.

- Зайнаас хяналт тавих хэлтсийн зүгээс банкны системийн чанаргүй зээл нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголбанкны 2016 оны дотоод ажлын төлөвлөгөөний дагуу Хас банк, Голомт банк, Чингис Хаан банкны 40 том зээлийг хянан шалгаж, энэ талаар улирал бүрийн банкинд зайнаас тавьсан хяналтын дүгнэлтэнд тусгах, холбогдох танилцуулга боловсруулан Хяналт шалгалтын зөвлөлийн гишүүд болон Монголбанкны удирдлагуудад танилцуулах замаар тухай бүр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Тайлант хугацаанд нийт 5 эрүү, иргэний хэрэгт нийт 9 хянан шалгагч шинжээчээр ажиллаж, шинжээчийн дүгнэлт гаргаж холбогдох хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР